

ᠪᠠᠶ᠋ᠠᠨᠬᠣᠩᠭᠣᠷ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ ᠭᠠᠰᠠᠷ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2022

Агуулга

ХУРААНГУЙ ТАЙЛАН	2
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН АУДИТ.....	9
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	12
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ	15
ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД АУДИТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ	15
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ.....	16
ДОЛДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	21
НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	Error! Bookmark not defined.
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХАВСРАЛТУУД	Error! Bookmark not defined.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АНГ	Аудитын нэгдүгээр газар
АГТ	Аудитын гуравдугаар газар
АОК	Аймгийн онцгой комисс
ББНЦК	Баримт бичиг нягтлан шалгах комисс
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИПХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МПТ	Мэдээлэл технологийн төв
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАК	Хувийн аудитын компани
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЧБГ	Чанарын баталгаажуулалтын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.06.24

ХУРААНГУЙ ТАЙЛАН

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2022 оны эхний хагас жилд 12 орон тоотойгоор ажилтантайгаар 11808 хүн/цаг ажиллахаас 13432 хүн/цаг буюу 1624 хүн/цаг илүү ажиллан дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлэв.

Тайлант хугацаанд 2022 оны эхний хагас жилд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар төлөвлөгөөт гүйцэтгэлийн 3 аудит, байгууллага өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн 1, хуулийн дагуу 1 нийтдээ шууд тайлагнах 6, үүнээс гүйцэтгэлийн 5 аудит, нийцлийн 1 аудит, санхүүгийн тайлангийн аудитад 264 байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан хамрагдсанаас 172 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргаж, үүнээс 148 байгууллага “Зөрчилгүй”, 23 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт гаргасан байна.

Аудитаар нийт 36,243.2 сая төгрөгийн 940 алдаа, зөрчил илэрч, 741.8 сая төгрөгийн 128 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 9,871.9 сая төгрөгийн 186 албан шаардлага хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэсэн 23,934.4 сая төгрөгийн 507 заалт бүхий зөвлөмж өгч, 1,695.1 сая төгрөгийн 119 алдааг санхүүгийн тайланд залруулж нийт хэрэгжилт 42.6%-ийн биелэлттэй байна. **Үүнээс:** санхүүгийн тайлангийн төлбөрийн актын 30.1 %, албан шаардлагын 47.1%, зөвлөмжийн 36.5%, нийт шийдвэрийн хэрэгжилтийг мөнгөн дүнгээр тооцоход 43.1 %-ийн биелэлттэй гарч өмнөх оноос 7.6 хурвиар өссөн байна. Шийдвэрийн биелэлтийг хэрэгжих хугацаагаар нь тооцвол төлбөрийн актын 90.8 %, албан шаардлагын 96.6% биелэлттэй гарсан байна.

Эхний хагас жилийн байдлаар актын төлбөр, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж хувиар тооцоход 42.6 %-тай байгаа нь төлөвлөгөөнд тусгагдсан санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитуудын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүйтэй холбоотой байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21,973.9 сая төгрөгийн 834 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 1,695.1 сая төгрөгийн 119 алдааг залруулж, 689.0 сая төгрөгийн 120 төлбөрийн акт тогтоож, 3,915.9 сая төгрөгийн зөрчилд 123

албан шаардлага өгч, 15,673.9 сая төгрөгийн зөрчилд алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 472 зөвлөмжийг төсвийн захирагч нарт хүргүүлж ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитын 84.8 хувийг буюу 224 байгууллагыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар өөрсдийн хүчээр гүйцэтгэж, 15.2 хувь буюу 40 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг “Баян ташаагийн эх аудит” ХХК 20 байгууллагад, “Глобал капитал аудит” ХХК компани 20 байгууллагатай гэрээ байгуулж, аудитыг гүйцэтгэсэн байна.



Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар нийт 4,314.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 9.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 38.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, 4,267.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 9 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Тайлант хугацаанд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 3, өөрийн санаачилгаар 1 гүйцэтгэлийн аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж нийт аудитаар нийт 14,269.3 сая төгрөгийн 105 зөрчил илрүүлснээс 8 зөрчилд 52.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийн арилгах 5,956.0 сая төгрөгийн 63 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 8,260.5 сая төгрөгийн 35 зөвлөмж хүргүүлж өгсөн. Тайланг 2022.04.29-ны өдөр 1/329 тоот албан бичгээр ҮАГ-т, 1/330 тоот албан бичгээр Нийслэл дэх ТАГ-т, 1/331 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Засаг даргад, 1/332 тоот албан бичгээр аймгийн ИТХ-д тус тус хүргүүлсэн.

МУЕА-ын тушаалаар 2022 оныг Төрийн аудитын байгууллагын хэмжээнд “Аудитын чанар хяналтын үр нөлөөг сайжруулах” зорилтыг дэвшүүлсний хүрээнд зорилтыг хэрэгжүүлэх ажлын дэд төлөвлөгөө боловсруулан дараах 5 арга хэмжээг тусгасан. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт үр нөлөө, үр дүн сэдэвт аудитын тайланг Ажлын хэсгийн хурлаар оруулах
2. “Чанарын хяналт болон нэгдсэн удирдлага хоёрын харилцан уялдаа, цаашдын чиг хандлага” сэдэвт сургалт
3. ҮАГ-аас холбогдох чиглэлүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж авах
4. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газартай хамтран Чанарын хяналтын сайн туршлагыг харуулсан үзүүлэх сургалт, хэлэлцүүлэг хийх.
5. Шууд тайлагнах болон нотлох ажилд хамаарах аудитын түвшинд үнэлгээ хийж, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах, тайлагнах /Архангай аймагтай хамтран/

Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд дараах ажлын хийж гүйцэтгэлээ.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт үр нөлөө, үр дүн сэдэвт аудитын тайланг Ажлын хэсгийн хурлаар оруулах:

Тус арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа болоогүй ч гэсэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д нэгдсэн удирдамжаар хийх гүйцэтгэлийн аудитын ажлын хүрээнд аудитын анхаарах, асуудал, чанарын хяналтын талаар аймгуудтай төлөвлөлтийн шатанд хэлэлцүүлэг хийсэн бөгөөд аудитын тайлагналын үе шатны баримтуудыг АНТАГ-аас 2022.06.03-2022.06.13 хооронд хүлээн авч, нэгтгэсэн тайланг бэлтгэж байна.

Мөн "Нэгдсэн сургалт-2022" сургалтын хөтөлбөрт тусгасан "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" нэгдсэн удирдамжтай аудитын хэлэлцүүлгийг бэлтгэн АНТАГ-ын аудаторуудад сургалтын хуваарийн дагуу 5 удаа хугацаанд нь хэлэлцүүлэг зохион байгуулсан нь тус арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил боллоо.

2. “Чанарын хяналт болон нэгдсэн удирдлага хоёрын харилцан уялдаа, цаашдын чиг хандлага” сэдэвт сургалт:

Тус арга хэмжээг 2022.06.22-ны өдөр Завхан аймаг дахь Төрийн аудитын газар зохион байгуулж ҮАГ-ын АНГ, ХБТГ-тай хамтран 13 аймагт сургалт, хэлэлцүүлэг

хийлээ. Сургалт хэлэлцүүлэгт АНГ-ын менежер Ж.Батсайхан илтгэл, мэдээлэл хийж, ХБТГ-ын менежер П.Цэнгүүн зөвлөгөө зөвлөмж өгөв. Сургалт, хэлэлцүүлгээр аймаг дахь Төрийн аудитын газрууд харилцан санаа бодлоо солилцлоо.

3. ҮАГ-аас холбогдох чиглэлүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж авах:

Төрийн аудитын байгууллагын "Нэгдсэн сургалт-2022" сургалтын арга хэмжээнд ажиллагсад бүрэн оролцож, дээрх сэдвийн хүрээнд ҮАГ-ын ХБТГ-ын сургагч багш нар хэлэлцүүлэг хийж, аудиторууд бүрэн идэвхтэй хамрагдав.

Бусад арга хэмжээний хувьд хэрэгжүүлэх хугацаа болоогүй бөгөөд "ҮАГ-аас холбогдох чиглэлүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж авах" арга хэмжээний хүрээн ЧБГ-аас түншийн үнэлгээний талаар сургалт авах хүсэлтийг 2022.06.09-нд тус газарт хүргүүлсэн болно.

Дэвшүүлсэн зорилтын хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар 7 хоног бүрийн 4 дэх өдөр ажлын тайланг ҮАГ-ын АНГ-т хугацаанд нь 4 удаа хүргүүлэн ажилласан.

Тайлант оны эхэнд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ОНХС-ын аудитын төлөвлөлтийн үе шатны чанарын хяналтыг уулзалт, хэлэлцүүлэг байдлаар 2022.03.01-ээс эхлэн зохион байгуулж ажилласан нь үр дүнгээ өгч Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх ОНХС-ын аудитын төлөвлөгөөг ҮАГ-ын АНГ, АГГ-ын чанарын хяналт, зөвлөмжийн дагуу хийж төлөвлөсөн хугацаандаа батлуулж аудитыг гүйцэтгэж байгаа нь чанарын хяналтын үр дүн гарч байна.

Тайлант оны эхний хагас жилд гүйцэтгэсэн Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,593.8 сая төгрөгийн 154, Гүйцэтгэлийн аудитаар 1,508.2 сая төгрөгийн 14 үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн ажилласан ба аудитаас нийтдээ 3,102.0 сая төгрөгийн 168 үр өгөөж тооцсоныг орон нутгийн төр захиргааны болон холбогдох байгууллагууд хүлээн зөвшөөрсөн ба зардлын 1 төгрөг тутмаас 13.55 төгрөгийн үр өгөөж гарсан байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дэвшүүлсэн зорилт: АУДИТЫН ЧАНАР ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ

Төрийн аудитын байгууллагын тайлант жилийн зорилтын хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар дараах ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнд:

1. Аудитын чанар хяналтын үр нөлөөг сайжруулах дэд ажлын төлөвлөгөөг боловсруулан ҮАГ-ын Чанарын баталгаажуулалтын газраар хянуулан 3 арга хэмжээг хэрэгжүүлэх Газрын даргаар 2022.02.24-ны өдөр батлуулсан. Тус төлөвлөгөөнд МУЕА-ын 2022.04.18-ны өдрийн А/35 дугаар тушаалаар 2 арга хэмжээг нэмж хэрэгжүүлэхээр дэд төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан.

2. Дотоод сургалтын төлөвлөгөөний чанарын хяналтын талаар сургалт хийх, ЧБГ-аас түншийн үнэлгээний талаар сургалт авах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд эхний хагас жилд дотооддоо аудитын чанарын хяналтын, ҮАГ-ын АНГ-аас чанарын тогтолцооны сургалтыг тус тус явуулсан. Чанарын баталгаажуулалтын түншийн үнэлгээний талаар сургалт авах хүсэлтийг ҮАГ-ын ЧБГ-т хүргүүлсэн болно.


3. ҮАГ-аас зохион байгуулсан нэгдсэн сургалтад ОНХС-ын аудитын талаар болон гүйцэтгэл, тайлагналын шатанд чанарын талаар анхаарах асуудлаар хэлэлцүүлгийг 5 удаа хийсэн нь аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас сайн туршлага судалсан өгөөжтэй арга хэмжээ болсон.

Байгууллагын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол улсын ерөнхий аудиторын орлогчийн тэргүүлэх аудитор Я.Сарансүх даргаар 2022.04.05-нд батлуулан ажиллахын зэрэгцээ дараах дэд төлөвлөгөөнүүдийг дотооддоо батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Үүнд:

- Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөө
- Байгууллагын баримт бичиг, нягтлан шалгах комисс болон өмч хамгаалах салбар зөвлөлийн 2022 онд хийх ажлын төлөвлөгөө
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө
- Харилцагч талуудын оролцооны дэд төлөвлөгөө
- “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги”-ын 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөө

Хүний нөөц: Тайлант онд нийт хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, дүрэм журмыг мөрдөн ажиллав. МУЕА-ын 2021 оны А/19 тоот тушаалаар Баянхонгор аймаг дахь 12 орон тоогоор бүрэн ажилласан.


МУЕА-ын 2021 оны А/126 тушаалаар батлагдсан Аймаг дахь Төрийн аудитын газрын албан тушаалын тодорхойлолтыг хэрэгжүүлж ажиллах Тамгын даргаас өгсөн чиглэлийн дагуу гэрээтээр ажилласан байсан бичиг хэргийн ажилтны гэрээг 2022.03.15-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлсөн.



Тайлант хугацаанд тул сул орон тоон гараагүй болно.

2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн зорилтод ажлаа үндсэн 12 ажилтантайгаар 11808 хүн/цаг ажиллахаас 13432 хүн/цаг буюу 1624 хүн/цаг илүү ажиллан бүрэн хэрэгжүүлэв.

Бүтэц, зохион байгуулалт: Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/02 тушаалаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.



Шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн Газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.02.08-НЫ Б/01 дугаар тушаалаар зохион байгуулалтыг шинэчлэн баталсан. Үүнд: Нотлох аудит 2 аудитор, шууд тайлагнах аудитад 7 аудитор, ажлын

ачааллаас шалтгаалан шууд тайлагнах аудитын аудиторууд хоорондоо ад шилжин ажиллах нь хэвээрээ байхаар зохион байгуулан ажилласан.

Тус аудитын газар нь өдөр тутмын ажлаа Удирдлагын ABLE системийн “АЖИЛ ХЭРЭГ” цэсийг ашиглан 7 хоногоор хийх ажлын төлөвлөгөө болон үүрэг

даалгаврын биелэлтэд нийт ажилтны шуурхай хурлаар хэлэлцэх байдлаар хяналт тавин удирдан зохион байгуулж ажилласан. Эхний хагас жилийн дүнгээр нийт 246 ажлыг өдөр тутам нэмж гүйцэтгэхээр оруулж хэрэгжилтийг хангасан.

Гүйцэтгэсэн аудит: Тайлант хугацаанд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.8-д заасан хугацаанд нийт 264 байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд аудит хийснээс 172 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргаж, үүнээс 148 байгууллага “Зөрчилгүй”, 23 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт гаргасан байна.

Сөрөг дүгнэлт авсан 1 байгууллагын удирдлагад “Төрийн аудитын тухай хууль”-ийн 42 дугаар зүйлийн 42.1-д зааснаар сахилгын шийтгэл ногдуулах саналыг хүргүүлэх хуулийн заалттай боловч “Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээ алба” УТҮГ-ын дарга нь ажлаас чөлөөлөгдсөн ажлыг тул эрх бүхий албан тушаалтанд саналыг хүргүүлээгүй болно.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар төлөвлөгөөт гүйцэтгэлийн 3 аудит, байгууллага өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн 1, хуулийн дагуу 1 нийтдээ шууд тайлагнах 6, үүнээс гүйцэтгэлийн 5 аудит, нийцлийн 1 аудитын тус тус гүйцэтгэж, тайлан, судалгааг хугацаанд нь холбогдох газруудад албан тоотоор хүргүүлсэн.

2022 оны эхний хагас жилд хийгдсэн санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитаар нийт 36,243,2 сая төгрөгийн 940 алдаа, зөрчил илэрч, 741.8 сая төгрөгийн 128 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 9,871.8 сая төгрөгийн 186 албан шаардлага хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэсэн 23,934.5 сая төгрөгийн 507 заалт бүхий зөвлөмж өгч, 1,695.1 сая төгрөгийн 119 алдааг санхүүгийн тайланд залруулж нийт хэрэгжилт 42.6%-ийн биелэлттэй байна. Үүнээс санхүүгийн тайлангийн төлбөрийн актын 30.1 %, албан шаардлагын 47.1%, зөвлөмжийн 36.5%, нийт шийдвэрийн хэрэгжилтийг мөнгөн дүнгээр тооцоход 43.1 %-ийн биелэлттэй гарч өмнөх оноос 7.6 хурвиар өссөн байна. Шийдвэрийн биелэлтийг хэрэгжих хугацаагаар нь тооцвол төлбөрийн актын 90.8 %, албан шаардлагын 96.6% биелэлттэй гарсан байна.

Тайлант оны эхний хагас жилд гүйцэтгэсэн аудитаас нийтдээ 3,102.0 сая төгрөгийн үр өгөөж тооцсоныг орон нутгийн төр захиргааны болон холбогдох

байгууллагууд хүлээн зөвшөөрсөн ба зардлын 1 төгрөг тутмаас 13.55 төгрөгийн үр өгөөж гарсан байна.

Хүснэгт: 1 Илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

/сая.төг/

Үзүүлэлт	Тогтоосон		Хэрэгжсэн		
	Тоо	дүн	Тоо	дүн	Хувь
Төлбөрийн акт	128	741.8	79	206.1	27.8
Албан шаардлага	186	9,871.9	72	1,845.5	18.7
Зөвлөмж	507	23,934.4	248	5,728.9	23.9
залруулга	119	1,695.1	119	1,695.1	100.0
Нийт дүн	940	36243.3	518	9475.6	42.6

Эхний хагас жилийн байдлаар актын төлбөр, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж хувиар тооцоход 42.6 %-тай байгаа нь төлөвлөгөөнд тусгагдсан санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитуудын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүйтэй холбоотой байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дахь заалтын хэрэгжилт:

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалтын дагуу 7 зөрчлийн 33,4 сая төгрөгийн албан шаардлагыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба болон төсөвт байгууллагад хүргүүлсэн.

Аймгийн Прокурорын газартай Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, төрийн төлөөлүүлж шүүхэд нэхэмжлэл гаргуулах талаар хамтран ажиллах санамж бичгийг 2022.04.28-нд байгуулсан.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8-д заасан Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн хэмжээнд 161 төсвийн байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн ерөнхийлөн захирагч 1, улсын төсвийн 32 нийт 264 байгууллагын санхүүгийн тайлан болон ангилагдаагүй зардал, замын сан, хяналтын барьцаа данс, засаг даргын нөөц хөрөнгийн данс нийт 5 дансны гүйлгээ нэгтгэгдсэнээс 264 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж 172 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 92 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.



Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 24 дүгээр тогтоолоор “Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ-ыг, Баян-Овоо сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг тус тус үүсгэн байгуулж санхүүгийн тайланг нэгтгэсэн ч тус байгууллагууд нь санхүүгийн тайлан, аудит хийлгэх хүсэлтийг ирүүлээгүй тул аудитад хамрагдаагүй болно.

Аудитад хамрагдаж санал дүгнэлт өгсөн 172 байгууллагын 148 байгууллагад “Зөрчилгүй”, 23 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгсөн.



Санхүүгийн тайлангийн аудитын 84.8 хувийг буюу 224 байгууллагыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар өөрсдийн хүчээр гүйцэтгэж, 15.2 хувь буюу 40 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг “Баян ташаагийн эх аудит” ХХК 20 байгууллагад, “Глобал капитал аудит” ХХК компани 20 байгууллагатай гэрээ байгуулж, аудитыг гүйцэтгэсэн байна.



Аудитад Төрийн аудитын байгууллагын үндсэн 9 аудитор, хараат бус аудитын 2 компанийн 6 аудитор гүйцэтгэн, үе шатны хяналтыг аудитын менежер, дарга тэргүүлэх аудитор хянан удирдан нийт 17 хүн 157 өдөр, 1442 илүү цаг ажиллан нийт 1,593.8 сая төгрөгийн үр өгөөж тооцов.

Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21,973.9 сая төгрөгийн 834 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 1,695.1 сая төгрөгийн 119 алдааг залруулж, 689.0 сая төгрөгийн 120 төлбөрийн акт тогтоож, 3,915.9 сая төгрөгийн зөрчилд 123 албан шаардлага өгч, 15,673.9 сая төгрөгийн зөрчилд алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 472 зөвлөмжийг төсвийн захирагч нарт хүргүүлж ажиллав.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА, ТБОНӨААН, ТТЗ, ТЕЗ-ийн 2021 оны жилийн эцсийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР:



Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар нийт 4,314.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 9.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 38.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, 4,267.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 9 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Тайлант хугацаанд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 3, өөрийн санаачилгаар 1 гүйцэтгэлийн аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хянан удирдаж 2 ажилтан, давхардсан тоогоор 21 аудитор 123 өдөр 182 илүү цаг ажиллан гүйцэтгэв.

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т хийгдэж буй аудитын тайлагналын үе шатны ажил хийгдэж байгаа, бусад гүйцэтгэлийн аудитаар нийт 14,269.3 сая төгрөгийн 105 зөрчил илрүүлснээс 8 зөрчилд 52.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийн арилгах 5,956.0 сая төгрөгийн 63 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 8,260.5 сая төгрөгийн 35 зөвлөмж хүргүүлж, 1,508.2 сая төгрөгийн 14 үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн байна.



“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудит;

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудитыг 2022.04.01-ээс 2020.05.05-ны хооронд хянан удирдаж 2 ажилтан, 2 аудитор 25 өдөр, 20 илүү цаг зарцуулан 2016-2021 оныг хамруулан шалгав.



Аудитаар нийт 261.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 10.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 251.6 сая төгрөгийн зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх 14 зөвлөмж өгсөн, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.



Тайланг дарга, тэргүүлэх аудиторын 2022.05.03-ны өдрийн А/12 тоот тушаалаар тайланг баталгаажуулан 2022.05.04-ний өдрийн 1/338 тоот албан бичгээр ҮАГ-ын АГГ, 339 тоот албан бичгээр аймгийн Засаг дарга, 1/340 тоот албан бичгээр аймгийн ИТХ-ын дарга, 1/341 тоот албан бичгээр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тус тус хүргүүлэв.

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийж байгаа аудит;

Тус аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2022.03.01-ний өдрөөс эхлэн гүйцэтгэн, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, хавсралт судалгаануудад тусгах саналыг АНТАГ-аас авч, ирүүлсэн саналуудыг тусган аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг ҮАГ-ын АНГ, АГГ-аар хянуулахаар 2022.03.23-ны өдөр 1/257 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ҮАГ-ын АГГ-ын 2022.03.28-ны өдрийн 08/97 дугаар дотоод албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт засвар хийж, МУЕА-ын орлогч, тэргүүлэх аудитор Я.Сарансүхээр 2022.04.14-ны өдөр батлуулсан. Тус аудиттай холбоотой баримт материалыг TEAMS программд оруулан хөтөлж явсан бөгөөд АНТАГ-аас аудитын тайлагналын үе шатны ажлын баримтуудыг хүлээн авч




ажиллан, нэгдсэн тайлан бичих ажлыг аудитын баг гүйцэтгэж байна. Баянхонгор аймгийн ОНХС-гийн бүрдүүлэлт зарцуулалт, үр нөлөө , үр дүнд хийсэн аудитыг хянан удирдаж 2 ажилтан, 4 аудитор 29 өдөр 116 хүн өдөр, 24 цаг илүү ажиллаж гүйцэтгэсэн ба аудитаар 5860.8 сая төгрөгийн 59 зөрчил илэрч, 48.3 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 4490.6 сая төгрөгийн 45 албан шаардлага, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх 1321.9 сая төгрөгийн 7 зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлж ажиллав.

“Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” хийсэн аудит;

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар тус аудитыг хянан удирдаж 2 ажилтан, 3 аудитор 30 өдөр, 60 илүү цаг ажиллан АДБОУС, MNS 6817-7:2020 стандартын дагуу чанартай гүйцэтгэн дүнг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, Газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.04.29-ны өдрийн А/11 тоот тушаалаар баталгаажуулав.

Аудитаар нийт 8147.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1,455.4 сая төгрөгийн 16 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 6687.0 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн. Тайланг 2022.04.29-ны өдөр 1/329 тоот албан бичгээр ҮАГ-т, 1/330 тоот албан бичгээр Нийслэл дэх ТАГ-т, 1/331 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Засаг даргад, 1/332 тоот албан бичгээр аймгийн ИТХ-д тус тус хүргүүлсэн. Аудитаар



1,439.7 сая төгрөгийн 6 үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн ажилласан ба шийдвэрийг хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” -т хийж байгаа аудит;

Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэж буй “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” аудитын дэд төлөвлөгөөг газрын дарга, тэргүүлэх аудитораар 2022.05.06-ны өдөр батлуулан, хянан удирдаж 2 ажилтан, 4 аудитор нар хамтран 6 хүн 39 өдөр, 78 илүү цагааг ажиллан гүйцэтгэж байна.

Аудитын талбарын ажлыг дуусган, үе шатны хяналтыг ЧХ-1, ЧХ-2 маягтаар хянуулан, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг аудитад хамрагдсан байгууллага бүрээр асуудлын бүртгэл бэлтгэн, танилцуулж асуудлын бүртгэлтэй тайлбар тодруулга авах ажиллагаа хийгдэж, тайлангийн төслийг бэлтгэж байна. Аудитын нийт ажлын гүйцэтгэл 80 хувь байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ

ТАБ-аас 2022 онд нэмэлтээр хийх, өмнөх оноос шилжиж ирсэн болон төлөвлөгөөт бус аудитыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох Монгол ардын нам, Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийг хүлээн авч, хянан удирдаж 2 ажилтан, 2 аудитор 17 өдөр ажиллан, дүгнэлтийг 2 нам болон Өлзийт сумын Сонгуулийн хороонд хүргүүлж, хуулийн хугацаанд байгууллагын цахим хуудаст сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт, намуудын мөрийн хөтөлбөрийг байршуулсан.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД АУДИТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

МУЕА-ын 2022 оны "А" тушаалын хэрэгжилтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар Орон нутаг дахь Төрийн аудитын газарт хамааралтай 14 -н биелэлтийг гаргаж УАГ-ын ЗУГ-т 2022.06.23-нд хүргүүлсэн.

Төрийн аудитын байгууллагын Удирдлагын шуурхай хуралдаанаас хагас жилийн өгсөн 3 үүргийн хэрэгжилтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнаж TEAMS-ийн дундын файлд оруулан ажилласан.

Төрийн аудитын байгууллагын 2022 оны удирдах ажилтны зөвлөгөөнөөс өгсөн 12 үүрэг даалгаврын хэрэгжилтийг TEAMS-ийн дундын файлд хугацаанд нь оруулан тайлагнасан.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ

Сургалт, хөгжил:

Байгууллагын 2022 оны сургалтын төлөвлөгөөг 2022.01.25-ны өдөр Газрын дарга, тэргүүлэх аудитораар батлуулсан бөгөөд ТАБ-ын нэгдсэн сургалтын төлөвлөгөөнд оруулах 3 саналыг 2022.01.05-ны өдөр хүргүүлэн ажиллаа.

2022 оны эхний хагас жилийн байдлаар 26 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 216 албан хаагч хамрагдсан байна. Үүнд:

ҮАГ-аас Нэгдсэн сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан

- Удирдах ажилтны сургалтад -1
- Төрөлжсөн аудитын 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор -41
- Чанарын хяналт сургалт хэлэлцүүлэгт - 10
- Мэдээллийн цагаар 3 удаагийн сургалтад - 33
- Хувь хүний хөгжлийн сургалтад -15

Нэгдсэн сургалт 2022: Байгууллагын албан хаагчид бүрэн оролцсон бөгөөд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” нэгдсэн удирдамжтай аудитын хэлэлцүүлгийг удирдан Бүлэг 2, Бүлэг 3, Бүлэг 4 -т амжилттай зохион байгуулж сургалтад давхардсан тоогоор -64 хүн хамруулсан.

Сургалт хөгжлийн цахим системийн сургалт

- Шинэ ажилтны 2 удаагийн сургалтад - 4 /1 ажилтан сорил шалгалтыг хугацаанд нь өгөөгүй/
- “Мэдээлэл харилцааны үндсэн ойлголт ба олон нийттэй харилцах арга” сэдэвт сургалтад -2
- Төрийн албан хэрэг хөтлөлтийн сургалтад -4

Дотоод сургалт

- Гүйцэтгэлийн аудиттай холбоо 2 сургалт – 10
- “Чанарын хяналт болон нэгдсэн удирдлага хоёрын харилцан уялдаа, цаашдын чиг хандлага” сургалт -11
- Мэдлэг ур чадвар нэмэгдүүлэх 4 сургалтад давхардсан тоогоор 17 ажилтан тус тус оролцож мэдлэг боловсролоо дээшлүүлсэн

Олон нийттэй харилцах:

Аудитын үйл ажиллагаанд иргэд, олон нийт, харилцагч талуудын оролцоог хангах идэвхжүүлэх зорилгоор “Харилцагч талуудын оролцооны дэд төлөвлөгөө”, “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратегийн 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөө”-нд нийт 14 арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажиллав.

Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл аудитын 2 мэдээллийг “Өнөөгийн Баянхонгор” сонинд нийтлүүлсэн. Радио телевиз 2, бусад байгууллагад 8 удаа мэдээлэл хийсэн.

Төрийн аудитын үйл ажиллагаа, www.openaudit.mn нээлттэй аудитын цахим хуудсаар дамжуулан иргэд хяналтын үүргээ хэрэгжүүлэх талаар гарын авлага сурталчилгааны материалыг дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж иргэдэд хүргэв. Үүнд:

- “Дижитал – Баянхонгор” арга хэмжээний хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг (танилцуулга, шторк, гарын авлага бэлтгэн 300ш тараав.)
- Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсний 100 жилийн ойн хүрээнд 100 дугуйчин 100 км “Бөмбөгөр-100” гэсэн аялалын арга хэмжээг аймгийн Дугуйн холбоотой хамтран зохион байгуулав. (дугуйчид амрах 5 өртөөний 1-г байгуулан дугуйчид болон бөмбөгөр сумын ард иргэдэд танилцуулга, гарын авлага 200 ш тараав.)



Эхний хагас жилд audit.mn цахим сайтад 403 мэдээлэл байршуулсан ба Гүйцэтгэлийн аудитын тайлан 3, Санхүүгийн тайлан-158, СТА-гийн аудитаар төлбөрийн акт-119, зөрчил арилгах албан шаардлага-123 мэдээлсэн.

“Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн танилцуулга”, “Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн”-гийн талаар 2 шторк олон нийтэд түгээсэн.



Төрийн аудитын газар Баянхонгор facebook хуудсаар дамжуулан Төрийн аудитын байгууллагын хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон цаг үеийн ажилтай холбоотой 65 мэдээллийг тухай бүр олон нийтийн сүлжээгээр хүргэн ажилласан.

Санхүүгийн аудитын тайланг 180 байгууллагад, шууд тайлагнах аудитын тайланг давхардсан тоогоор 51 байгууллагад хүргүүлж, мөн хүсэлтийн дагуу давхардсан тоогоор 80 аудитын тайланг бусдад хувилж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяаны байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүн дүгнэлт, илэрсэн зөрчлийн талаар аймгийн ИТХ-ын Эдийн засгийн хороонд танилцуулга хийв.



Санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн тухай танилцуулга, зөвлөмж бэлтгэж Төсвийн захирагч нар мэдээлэл хийж, Засаг дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэгт албан бичгээр хүргүүлсэн.

Мэдээлэл технологи:

Тайлант хугацаанд сүлжээний доголдол гараагүй бөгөөд аудиторуудын компьютерыг хэвийн ажиллах нөхцөлийг хангаж ажиллав. Албан хаагчийн компьютерт давхардсан тоогоор 2 удаа үйлдлийн систем шинэчлэн суулгасан.

ҮАГ-ын мэдээлэл технологийн албанаас нэгдсэн журмаар суулгасан хортой кодын эсрэг программ хэвийн бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажилласан.

ҮАГ-аас нэвтрүүлсэн статистик мэдээний, шилэн дансны local.audit.mn, санхүүгийн аудитын fas.audit.mn, аудитын үйл явцын data.audit.mn зэрэг программуудыг ажиллахад сүлжээний болон техникийн хувь бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан байна.

Авлига, ашиг сонирхол, ёс зүй, ХАСХОМ:

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу ХАСХОМ гаргах албан тушаалтнуудын жагсаалтыг 2022 оны 01 дүгээр сард ҮАГ-т хүргэж, 2021 оны ХАСХОМ-ыг хуулийн

хугацаанд буюу 2022.01.17-ны өдөр гаргаж мэдээллийг ХАСХОМ-ын бүрдүүлэлтийн системд бүрэн оруулж баталгаажуулсан. Тайланг хоцроосон, мэдээлээгүй албан хаагч байхгүй, тайланг албажуулан 2022.01.21-ний өдөр ҮАГ-т хүргүүлсэн.

"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө"-нд 11 ажлыг хийхээр төлөвлөн, байгууллагын даргаар 2022.01.05-ны өдөр батлуулж, батлагдсан төлөвлөгөөг ҮАГ болон аймгийн ЗДТГ-т хүргүүлж ажиллав.

Тайлант жилийн эхний хагаст гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудыг хэрэгжилтийг ханган ажлын тайланг 2021.06.16-ний өдөр ҮАГ-т албан 1/373, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст 1/372, дугаар албан бичгээр хүргүүлж ажиллав.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу байгууллагын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбатын 2021.12.20-ны өдөр гаргасан зөрчил үүссэн тухай мэдэгдлийг ҮАГ-т явуулсан байсныг МУЕА-ын орлогч, тэргүүлэх аудитор Я.Сарансүх 2022.01.20-ны өдрийн 01/135 албан бичгээр шийдвэрлэж ирүүлснийг ХАСХОМ-ын бүрдүүлэлтийн системд мэдээллийг бүрэн оруулсан байна. Мөн тайлант хугацаанд дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбатын, ахлах аудитор М.Алтантуяагийн ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийг холбогдох арга хэмжээ авсныг байгууллагын шилэн данс, <https://meduuleg.iaac.mn>-д тухай бүр нь мэдээлж ажиллав.

Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт:

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь "Төрийн байгууллага нь төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг ҮАГ-ын Захиргаа, удирдлагын хэлтэст 2022.01.19-ний өдөр 140, Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэст 1/39 дүгээр албан бичгээр хүргүүлж ажиллав.

Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэст 2021.06.15-ны өдөр 2022 онд гадаад улсад зорчсон албан хаагч байхгүй тухай 1/369 тоот албан бичгийг хүргүүлсэн.

Байгууллагад ашиглаж байгаа лацны бүртгэлийг оны эхэнд, мөн архив, бичгийн хэргийн ажилтан ажлаас чөлөөлөгдсөн тул лацны бүртгэлийг шинэчлэн албажуулан ажиллав.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж байгаа, учруулж болзошгүй эрсдэлтэй асуудал тайлант хугацаанд гараагүй, шууд гүйцэтгэх аудитын 3 тайлан, аймгийн ТЕЗ-ийн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэгт албан бичгээр тухай бүр хүргүүлж ажилласан байна.

Архив, бичиг хэргийн хөтлөлт :

Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комисс 2022 онд 7 ажил, бичиг хэрэг, архивын 13 ажил хийхээр тус тус дэд төлөвлөгөөг боловсруулан батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Байгууллагын албан бичиг хэргийн хөтлөлтөд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан бичиг хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Монгол улсын стандарт MNS 5140-1,2,3 2021-ыг мөрдөн ажиллаж байна.

ББНШК 2022 онд хийхээр төлөвлөсөн ажлаас хугацаа нь болсон 6 ажлын хэрэгжилтийг хангаж бичиг хэргийн ажилтан болон бусад ажилтнуудад зөвлөгөө өгч биелэлтийг тооцон арга зүйн удирдлагаар хангасан.

Төрийн аудитын газрын 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу үүсгэсэн 2019 оны байнга хадгалах 28 төрлийн баримтыг архив албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу шалгуулан цаасан болон цахим хэлбэрээр ашиглалтын хувь үүсгэн Цахим архивыг аймгийн Төрийн архивын тасагт хүлээлгэн өгсөн.

Тайлант хугацаанд цахимаар 27, бусад байгууллага албан тушаалтнаас 368 нийт 395 албан бичгийг хүлээн авч, гаднын болон системийн байгууллагад 384 албан бичиг, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлт 172 нийт 556 албан бичгийг хэвлэмэл хуудас дээр гарган хүргүүлсэн бөгөөд төрийн албан хэрэг хөтлөлтийн Able программ, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын ERP нэгдсэн системд бүрэн бүртгэж, холбогдох албан тушаалтнуудад цахимаар шилжүүлэн шийдвэрлүүлж гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан.

Аймгийн Төрийн архивын тасгаас албан шаардлагын хэвлэмэл хуудас 152 ширхэг, А-4, А-5 хэвлэмэл хуудсыг тус тус 200 ширхгийг захиалан авсан бөгөөд зарцуулалтын тайлан гаргаж хяналт тавин ажиллаж байна.

Хэвлэмэл хуудасны зарцуулалтад 2022.05.06-ны өдөр шалгалт хийхэд бичиг хэргийн стандартын алдаа гаргаснаас төлбөрийн актын 7, албан шаардлагын 3, албан хэвлэмэл хуудаснаас А5 албан хуудас 9, А4 албан хуудас 28-ийг тус тус хүчингүй болгосон бөгөөд холбогдох албан хаагчдаар төлүүлсэн.

Байгууллагын архивд 1995-2021 он хүртэл аудитын тайлан, шалгалтын материал хадгалагдаж байгааг төрийн архивд шилжүүлэн цахимд оруулах ажлыг 2021 оноос шинээр хэрэгжүүлж бөгөөд аймгийн Төрийн архивын тасагт 2018 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын байнга хадгалах шалгалтын материал болох 294 нэгж (46320 хуудас) баримтыг хүлээлгэн өгч гэрээ байгуулав.

Архивын ажилтан нь архивын өрөөнд байвал зохих галын аюулгүйн тэмдэг, галын хор, хүрз, температур болон чийг хэмжигч, элс, ус хадгалах сав, баримт зөөх уут, камержуулалд зэрэг шаардлагатай багаж хэрэгслийн бүрэн байдалд хяналт тавин, өрөөний агааржуулалт температурыг тогтмол шалгаж, стандартын дагуу хяналт тавин ажиллав.

Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд ямар нэгэн өргөдөл гомдол ирээгүй болно.

Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг утгасан арга хэмжээ:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олон ТАБ-ын үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд “Бөмбөгөр-100” буюу 100 км 100 дугуйчин арга хэмжээнд хамтран зохион байгууллаа.

Төрийн хяналтын байгууллагын 100 жилийн ойд зориулсан Онол, практикийн бага хуралд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 3 ажилтан илтгэл бэлтгэн оролцож байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Санхүүжилтийн орлого:

Тайлант онд 511.0 сая төгрөгийн төсөв батлагдсан ба хагас жилийн байдлаар 261.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч 228.8 сая төгрөгийг зардлын бүлэг тус

бүрээр зориулалтын дагуу зарцуулж 2022.06.23-ны байдлаар Төрийн сан банк дахь 100030024001 тоот харилцах дансны үлдэгдэл 32.8 сая төгрөг байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого:

Нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банк дахь 100030024401 тоот дансанд ХАК-ын санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэсэн ажлын үйлчилгээний төлбөрт 13.4 сая, Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөр Баянхонгор Үйлдвэржилт Хөгжлийн Корпорацаас 0.5 сая, данс андуурсан гүйлгээний 0.4 сая, тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрт 0.4 сая нийт 14.7 сая төгрөгт төвлөрснөөс тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний төлбөрт нөхөн төлбөрт 0.4 сая, ХАК-тай хийсэн гэрээг дүгнэж Глобал аудит ХХК-д төсөвт байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн үйлчилгээний төлбөр 6.6 сая төгрөгийг зарцуулж 2022.06.22-ны байдлаар тус дансны үлдэгдэл нийт 7.7 сая төгрөг байна.

Зардлын зарцуулалт:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ба зардал тус бүрээр хүлээгдэж буй гүйцэтгэлээр харуулбал:

Хүснэгт: 1 /мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлагын дүн	261,647	228,823.6	32,823.2	87.5
Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	218,692.0	191,709.1	26,982.9	87.7
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	26,536.8	23,485.1	3,051.7	88.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	344.0	344.0	-	100.0
Хангамж бараа материалын дүн	4,914	4,914	0	100.0
Бичиг хэрэг	1,663.8	1,340.9	322.9	80.6
Тээвэр, шатахуун	1,773.6	1,984.4	(210.8)	111.9
Шуудан холбоо	396.9	308.6	88.3	77.8
Ном	-	-	-	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зардал	1,080.0	1,280.2	(200.2)	-
Эд хогшил, урсгал засварын дүн	2,000.0	2,000.0	-	100.0
Дотоод албан томилолтын зардал	6,532.8	3,958.0	2,574.8	60.6
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний дүн	2,426.9	2,213.3	213.6	91.2
Төлбөр хураамж бусад	1,001.7	975.0	26.7	97.3
Даатгалын үйлчилгээ	763.0	763.0	-	100.0
Тээврийн татвар	282.2	131.3	150.9	46.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	80.0	44.0	36.0	55.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300.0	300.0	-	100.0
Ажил олгогчоос олгосон тэтгэмж, урамшуулал	200.0	200.0	-	100.0
Эх үүсвэрийн дүн	261,646.8	261,646.8	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	261,646.8	261,646.8	-	100.0
Үндсэн дансны МХ-н 2022 оны 06-р сарын 22-ний байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр үлдэгдэл		32,823.2		

Байгууллагын тоо	1	1	-	
Ажиллагсад бүгд	12	12	-	
Удирдах ажилтан	1	1	-	
Гүйцэтгэх ажилтан	10	10	-	
Үйлчлэх ажилтан	1	1	-	
Гэрээт ажилтан	0	0	-	

Санхүүгийн мэдээ тайлан:

Байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг Мишээл Од ХХК-аар хийлгэн “Зөрчилгүй санал” дүгнэлтийг авсан болно.

Мөн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, НДШ-н НД7,8 мэдээ сар бүр, татварын тайланг улирал бүр гаран холбогдох байгууллагад нь, санхүүгийн эхний хагас жилийн тайланг гаргаж ҮАГ-т цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.

Байгууллагын хөрөнгийн тооллогыг Дарга, Тэргүүлэх аудиторын 2022.05.23-ны өдрийн А/14 тоот тушаалаар Тооллогын комисс томилогдон 05 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн ба төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллоготой холбоотой ТӨБЗГ-ын <http://pcsp.gov.mn/> системд байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тооллогын программд холбогдох мэдээллийг бүрэн шивж оруулсан.

Баянхонгор аймагт ажиллаж байгаа ТӨБЗГ болон аймгийн ОНӨГ-аас томилогдсон хяналтын тооллогын комисс 2022.06.22-ны өдөр байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналтын тооллого хийж, хадгалалт хамгаалалт, бүртэл тооцоо, байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаа тайлан мэдээнд үнэлэлт дүгнэлтийг хийж ТӨБЗГ-тай хийсэн “Өмч эзэмшлийн гэрээ”-г дүгнэж гэрээг сунгасан. Төрийн өмчийн Улсын тооллого, үзлэгээр 96 хувь буюу “хангалттай сайн” үнэлэгдлээ.

ТАГ-ын 2023 оны төсвийн төслийг боловсруулж ҮАГ-т 2022.05.24-ний өдрийн 1/356 тоот албан бичгээр, 2022 оны хуваарийн өөрчлөлт оруулах саналыг тухай бүр ҮАГ-т хүргүүлснээр төсвийн хуваарь өөрчлөлт орж өнөөдрийн байдлаар өр, авлагагүй ажиллаж байна.

Шилэн дансны мэдээллийн талаар:

Шилэн дансны портал сайтад Бүтэн жилээр байршуулах 11 мэдээллээс хугацаа болсон 4 мэдээллийг хугацаанд нь шилэн дансны цахим хуудаст бүрэн байршуулсан, хагас жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээ, улирал бүр байршуулах 1 төрлийн 2 мэдээ, сар бүр байршуулах 3 төрлийн 18 мэдээ, тухай бүр байршуулах 8 төрөл 48, нийт 76 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан.

Мэдээлэл байршуулах хугацаа	Байршуулбал зохих мэдээлэл	Хугацаандаа байршуулсан мэдээлэл
Сар бүр	18	18
Улирал бүр	2	2
Хагас жил	4	4
Тухай бүр	48	48
Бүтэн жил	4	4
Нийт	76	76